Сэтгэцийн эрүүл мэндийн мэргэшсэн сувилагчдийг чадавхжуулах туршилт сургалтын хэрэгцээний асуудалд

Л.Одгэрэл[1], Д.Солонго[1], Fiona Nolan[2], Б.Оюунгоо[1], З.Хишигсүрэн[3]

[1]АШУҮИС, Сувилахуйн сургууль
[2]Anglia Ruskin University
[3]АШУҮИС, АУС
Цахим шуудан: odgerel.l@mnums.edu.mn, Утас: 94947755

Түлхүүр үг:

Мэргэшил
Хөтөлбөр
Сургалт
Үнэлгээ
Сувилагч

Товч утга: Дэлхийн улс орнуудад Сэтгэцийн эрүүл мэнд-ийн сувилагчийг мэргэшүүлэхэд 6-14 сарын хугацаатай бэлтгэдэг байна[2]. Монгол улсын хэмжээнд АШУҮИС-ийн Сувилахуйн сургууль, СЭМҮТ зэрэг байгууллагууд энэ чиглэлээр төгсөлтийн дараах сургалтыг 3-4 сараар бэлтгэж байна[1] Сэтгэцийн сувилагч бэлтгэдэг сургуулиудын сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуй хичээлийн сургалтын цаг, кредит, суралцах хугацаа бага байгаа нь суралцагчдын мэдлэг, чадвар, хандлага өөртөө итгэлтэй байдалд нөлөөлдөг байна[3]. **Зорилго:** Сэтгэцийн эрүүл мэндийн мэргэшсэн сувилагчдийг чадавхжуулах туршилт сургалтын хэрэгцээг судлахад оршино. **Арга, аргачлал:** Сэтгэцийн эрүүл мэндийн мэргэшсэн сувилагчдыг чадвахжуулах 6 сарын сургалтанд үнэлгээ хийхдээ дескриптив судалгааны загвараар хийв. Судалгаанд СЭМҮТ, Наркологийн төв эмнэлэг, орон нутгийн сэтгэцийн эрүүл мэндийн кабинетийн сувилагч зэрэг нийт 17 сувилагчийг хамруулсан. Судалгааны ёс зүйн зөвшөөрлийг 2020 оны 06 сарын 12-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн зөвшөөрөл авч судалгааг 2020 оны 06-р сарын 20-ны өдрөөс 2021 оны 10 дугаар сарын хооронд хийв. Судалгаанд мэргэшсэн сувилагчдын өөртөө итгэлтэй байдлыг үнэлэх (Fiona Nolan нарын (2018) confidence level of mental health registered nurses scales. Anglia Ruskin University) 24 асуулга бүхий стандарт хуудсыг хэрэглэсэн. Судалгааны зорилтын хүрээнд мэдээ, мэдээлэл цуглуулахдаа тоон судалгааны асуумжийн аргыг хэрэглэв.Тасралтгүй тоон хувьсагчуудын арифметикийн дунджийн ялгааг харьцуулахдаа T тест, ANOVA тестийг ашиглан харьцуулсан. Категорийн хувьсагчдад хи-квадратыг хэрэглэн статистикийн анализ хийсэн. Судалгааны боловсруулалтыг SPSS-24 программ ашиглан хийв. **Үр дүн:** Судалгаанд нийт 17 сувилагч хамрагдсанаас эрэгтэй n=2 (12%), эмэгтэй n=15 (88%) дундаж нас 36.3±9.4 байна. Суралцагсад 100% энэ чиглэлээр мэргэшсэн сувилагч нар байлаа. Судалгаанд хамрагдагсдын 30% нь хөдөө орон нутаг, 70% нь УБ хотоос хамрагдсан байна. Сургалтанд хамрагдагсад 6 сарын сургалтын явцыг 95% сэтгэл ханамжтай, 5% нь сэтгэл ханамж дундуур (онлайнаар сурахад сүлжээ дата хомс, комьпютерийн мэдлэг дутмаг) байна. **Дүгнэлт:** Сэтгэцийн эрүүл мэндийн мэргэшсэн сувилагчдыг чадавхжуулах 6 сарын сургалтыг цаашид үргэлжлүүлэн явуулж, мэргэшсэн сувилагчдыг чадвахжуулах шаардлагатай бөгөөд сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн чиглэлээрх мэргэшсэн багшийг бэлтгэх хэрэгцээ их байгаа нь харагдаж байна.

Үндэслэл: Дэлхийн анагаахын боловсролын холбоо (WFME) юм. Анагаахын боловсролын төгсөлтийн дараах сургалтын стандарт нь тухайн улс орны хэмжээнд тодорхойлогдсон, өөрчлөгдөн шинэчилэгдэж байх баримт юм. Сургалтын хөтөлбөрийн жигд байдлыг хангахгүй, суралцагчдад чиглэсэн сургалтын үйл ажиллагааг доголдуулах нь нийгмийн хариуцлагыг алдагдуулж байдгийг дурьджээ.[1,2] Төгсөлтийн дараах сургалтын үр дүнд суралцагчдын чадвар, сургалтын үнэлгээ, сургалтын орчин чухал байдаг[2].

Монгол улсын хэмжээнд АШУҮИС-ийн Сувилахуйн сургууль, АШУҮИС-ийн СЭМҮТ зэрэг байгууллагууд Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн чиглэлээр төгсөлтийн дараах сургалтаар “Сэтгэцийн

эрүүл мэндийн сувилагч”-ийг 3-4 сараар бэлтгэж байна[3]. Сэтгэцийн сувилагч бэлтгэдэг сургуулиудын сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуй хичээлийн сургалтын цаг, кредит, суралцах хугацаа бага байгаа нь суралцагчдын мэдлэг, чадвар, хандлага өөртөө итгэлтэй байдалд нөлөөлдөг байна[3]. Дээрх сургуулиудын сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуй хичээлийн хөтөлбөрийн нэршил, агуулга харилцан адилгүй, сургалтын орчин, сургалтын арга барил нь орчин үеийн хандлагын жишгээр боловсронгуй болж хөгжөөгүй байна.[4] Мэргэшүүлэх сургалт явуулдаг байгууллагуудын сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуй хичээлийн хөтөлбөрийн агуулга орчин үеийн хандлагын жишгээр боловсронгуй болж чадаагүй тул сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр мэргэшсэн сувилагчдыг чадавхжуулах 6 сарын сургалтанд оролцогчдоос сургалтын хэрэгцээг үнэлэх нь зорилго нь энэхүү судалгааны үндэслэл болно.

Зорилго: Сэтгэцийн эрүүл мэндийн мэргэшсэн сувилагчдийг чадавхжуулах туршилт сургалтын хэрэгцээг тодорхойлоход судалгааны зорилго оршино.


Зорилт:

1. Сэтгэцийн эрүүл мэндийн мэргэшсэн сувилагчийг чадавхжуулах сургалтын хэрэгцээг тодорхойлох.
2. Сэтгэцийн эрүүл мэндийн мэргэшсэн сувилагчийг чадавхжуулах сургалтын төгсөлтийн өмнөх болон дараах үнэлгээг харьцуулах.

Арга, аргачлал: Сэтгэцийн эрүүл мэндийн мэргэшсэн сувилагчдыг чадавхжуулах 6 сарын сургалтанд үнэлгээ хийхдээ дескриптив судалгааны загвараар хийв. Судалгаанд СЭМҮТ, Наркологийн төв эмнэлэг, орон нутгийн сэтгэцийн эрүүл мэндийн кабинетийн сувилагч зэрэг нийт 17 сувилагчийг хамруулсан. Судалгааны ёс зүйн зөвшөөрлийг 2020 оны 06 сарын 12-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн зөвшөөрөл авч судалгааг 2020 оны 06-р сарын 20-ны өдрөөс 2021 оны 10 дугаар сарын хооронд хийв. Судалгаанд мэргэшсэн сувилагчдын өөртөө итгэлтэй байдлыг үнэлэх (Fiona Nolan нарын (2018) confidence level of mental health registered nurses scales. Anglia Ruskin University) 24 асуулга бүхий стандарт хуудсыг хэрэглэсэн. Судалгааны зорилтын хүрээнд мэдээ, мэдээлэл цуглуулахдаа тоон судалгааны асуумжийн аргыг хэрэглэв.Тасралтгүй тоон хувьсагчуудын арифметикийн дунджийн ялгааг харьцуулахдаа T тест, ANOVA тестийг ашиглан харьцуулсан. Категорийн хувьсагчдад хи-квадратыг хэрэглэн статистикийн анализ хийсэн. Судалгааны боловсруулалтыг SPSS-24 программ ашиглан хийв.

Үр дүн: Судалгаанд нийт 17 сувилагч хамрагдсанаас эрэгтэй n=2 (12%), эмэгтэй n=15 (88%) дундаж нас 36.3±9.4 байна. Суралцагсад 100% энэ чиглэлээр мэргэшсэн сувилагч нар байлаа. Судалгаанд хамрагдагсдын 30% нь хөдөө орон нутаг, 70% нь УБ хотоос хамрагдсан байна. Сэтгэцийн эрүүл мэндийн мэргэшсэн сувилагчийг чадавхжуулах төгсөлтийн дараах сургалтын хугацааны сэтгэл ханамжийг судлахад нийт төгсөгчдийн 95% нь сэтгэл ханамжтай, 5% нь сэтгэл ханамжгүй байв. Суралцагчдаас Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн чиглэлээр цаашид бусад орнуудад мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдах сонирхолтой байгаа эсэхэд 64% нь тийм (p=0.43), 36% нь цаашид суралцах сонирхолгүй байна.

Сэтгэцийн эрүүл мэндийн мэргэшсэн сувилагчдаас төгсөлтийн дараах сургалтын хугацааг цаашид ямар хугацаагаар бэлтгэх нь тохиромжтой эсэхийг асуумж судалгаагаар тодруулахад 37.5% нь хугацааг сунгах шаардлагагүй буюу 3 сар байх нь хангалттай гэж үзсэн бол 2.1% 3 сар, 2.1% нь 4 сар, 43.1% нь 6 сар, 12.5% нь 9 сар байх нь тохиромжтой гэж хариулсанаас үзвэл цаашид сувилагч нарт энэхүү сургалт хэрэгцээтэй байгааг харуулж байна. (Зураг 1)



Зураг 1. Төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтын хугацааг сунгах эсэх

Хүснэгт 1-ээс харахад Сэтгэцийн мэргэшсэн сувилагчид 6 сарын сургалтын өмнө болон дараах өөртөө итгэлтэй байдалд үнэлгээ өгснийг харьцуулан үзэхэд нийт 24 асуумжид 1,2,8,9,10,11,12,13,14 (Сэтгэл түгших эмгэгтэй хүнтэй ажиллах чадвар, Сэтгэл гутрал, сэтгэлзүйн тогтворгүй байдалтай хүнтэй ажиллах чадвар, Тэнэгрэлтэй хүнтэй ажиллах чадвар, Бие хүний эмгэгтэй хүнтэй ажиллах чадвар, Сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудалтай хүүхэд, өсвөр насныхантай ажиллах чадвар, Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүнтэй харилцаа тогтоох чадвар, Сэтгэцийн эмгэгтэй хүний гэр бүлд сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх чадвар, Сэтгэцийн эмгэгтэй хүний эрүүл мэндийн нөхцөл байдал, одоогийн биеийн байдлын талаар гэр бүлийнхэнд нь мэдээлэл өгөх чадвар, Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн асуудал, одоогийн биеийн байдлын талаар эрүүл мэндийн салбарын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдтэй ярилцах, тайлбарлах чадвар) дүгээр чадваруудыг эзэмших чадвар дутмаг байсан бол эдгээр чадварууд 6 сар суралцсаны дараа эрс сайжирсан үзүүлэлтэй байлаа.

Хүснэгт 1. Мэргэшсэн сувилагчдын өөртөө итгэлтэй байдлыг хувиар үзүүлсэн байдал

Өөртөө итгэлтэй байдлын шалгуур		Сургалтын өмнөх				Сургалтын дараах				
		1.00	2.00	3.00	4.00	1.00	2.00	3.00	4.00	34.00
Working with people who have anxiety	Count	0	5	8	4	1	0	6	10	0
	N %	0.0%	14.7%	23.5%	11.8%	2.9%	0.0%	17.6%	29.4%	0.0%
Working with people who have a mood disorder, for example depression	Count	0	5	8	4	0	1	7	9	0
	N %	0.0%	14.7%	23.5%	11.8%	0.0%	2.9%	20.6%	26.5%	0.0%
Working with people who have psychosis, for example schizophrenia	Count	1	3	8	5	0	1	4	12	0
	N %	2.9%	8.8%	23.5%	14.7%	0.0%	2.9%	11.8%	35.3%	0.0%
Working with people who abuse alcohol	Count	2	2	9	4	1	1	5	10	0
	N %	5.9%	5.9%	26.5%	11.8%	2.9%	2.9%	14.7%	29.4%	0.0%
Working with people who use illegal substances	Count	2	2	10	3	0	1	7	8	1
	N %	5.9%	5.9%	29.4%	8.8%	0.0%	2.9%	20.6%	23.5%	2.9%
Working with people who have suicidal thoughts	Count	1	3	9	4	1	0	8	8	0
	N %	2.9%	8.8%	26.5%	11.8%	2.9%	0.0%	23.5%	23.5%	0.0%
Working with people who are aggressive	Count	1	7	8	1	1	2	3	11	0
	N %	2.9%	20.6%	23.5%	2.9%	2.9%	5.9%	8.8%	32.4%	0.0%
Working with people who have dementia	Count	0	4	10	3	0	0	3	13	0
	N %	0.0%	12.1%	30.3%	9.1%	0.0%	0.0%	9.1%	39.4%	0.0%
Working with people who have personality disorder	Count	0	5	10	2	0	1	7	9	0
	N %	0.0%	14.7%	29.4%	5.9%	0.0%	2.9%	20.6%	26.5%	0.0%
Working with children and adolescents with a mental health problem	Count	0	5	10	2	0	1	1	15	0
	N %	0.0%	14.7%	29.4%	5.9%	0.0%	2.9%	2.9%	44.1%	0.0%
Building a therapeutic relationship with people who have a mental illness	Count	0	4	9	4	0	0	2	15	0
	N %	0.0%	11.8%	26.5%	11.8%	0.0%	0.0%	5.9%	44.1%	0.0%
Providing emotional support to the families of a person with mental illness	Count	0	5	5	7	0	1	3	13	0
	N %	0.0%	14.7%	14.7%	20.6%	0.0%	2.9%	8.8%	38.2%	0.0%
Providing information regarding mental health conditions to family members	Count	0	4	5	8	0	0	5	12	0
	N %	0.0%	11.8%	14.7%	23.5%	0.0%	0.0%	14.7%	35.3%	0.0%
Communicating clearly about all aspects of a patient's mental health to professionals of all disciplines	Count	0	7	6	4	0	0	4	13	0
	N %	0.0%	20.6%	17.6%	11.8%	0.0%	0.0%	11.8%	38.2%	0.0%
Identifying and raising areas for improvement in the practice of your clinical team	Count	1	5	9	2	0	0	8	9	0
	N %	2.9%	14.7%	26.5%	5.9%	0.0%	0.0%	23.5%	26.5%	0.0%
Conducting research or audit as part of team	Count	1	8	6	2	0	0	7	10	0
	N %	2.9%	23.5%	17.6%	5.9%	0.0%	0.0%	20.6%	29.4%	0.0%
Leading on research projects or audits	Count	3	13	1	0	0	0	6	11	0
	N %	8.8%	38.2%	2.9%	0.0%	0.0%	0.0%	17.6%	32.4%	0.0%
Informing clinicians of any profession if you disagree with an aspect of their approach to the treatment of a patient	Count	5	5	5	2	0	0	7	10	0
	N %	14.7%	14.7%	14.7%	5.9%	0.0%	0.0%	20.6%	29.4%	0.0%
Accessing the most recent evidence about how best to treat mental illness	Count	4	9	4	0	0	0	8	9	0
	N %	11.8%	26.5%	11.8%	0.0%	0.0%	0.0%	23.5%	26.5%	0.0%
Assessing patients' clinical needs	Count	0	8	5	4	0	1	3	13	0
	N %	0.0%	23.5%	14.7%	11.8%	0.0%	2.9%	8.8%	38.2%	0.0%
Informing patients and relatives about the effects and side effects of medication	Count	1	8	5	3	0	0	3	14	0
	N %	2.9%	23.5%	14.7%	8.8%	0.0%	0.0%	8.8%	41.2%	0.0%
Planning and organizing an individual patient's care	Count	3	9	5	0	0	1	3	13	0
	N %	8.8%	26.5%	14.7%	0.0%	0.0%	2.9%	8.8%	38.2%	0.0%
Entering clinical information on to a computer	Count	1	8	8	0	0	1	2	14	0
	N %	2.9%	23.5%	23.5%	0.0%	0.0%	2.9%	5.9%	41.2%	0.0%
Undertaking health promotion activities with individual patients	Count	3	11	3	0	0	0	3	14	0
	N %	8.8%	32.4%	8.8%	0.0%	0.0%	0.0%	8.8%	41.2%	0.0%

Хэлцэмж: Австралийн төгсөлтийн дараах (PG) сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн сургалтын мэргэшсэн сувилагчдын мэдлэг, чадварыг судлах зорилготой хийгдсэн чанарын судалгаанд сэтгэцийн эрүүл мэндийн сувилагчийн мэдлэг, чадварыг тасралтгүй хөгжүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийн төгсөлтийн дараах сувилахуйн судалгааг хөгжүүлэх, сайжруулах нь тулгамдсан асуудал болж байна[5].гэсэн нь бидний судалгаанд хамрагдсан сувилагчдын 65.3% нь төгсөлтийн дараах сургалтаас хойш ямар нэгэн судалгааны ажил хийгээгүй, илтгэл өгүүлэл бичээгүй байгаа нь мэргэшсэн сувилагч нарыг энэ чиглэлээр судалгааны ажил хийх боломжгүй, цаашид өөрсдийгөө хөгжүүлэх шаардлагатай байдаг гэсэн үр дүнтэй дүйцэж байна.

Ickley M.T, Forbes M. нар (2010) судалгаандаа сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахад сургалтын хугацааг уртасгах, шинэчлэлт хийх хэрэгтэйг хөндсөн байна[7]. Бид судалгаандаа мэргэшсэн сувилагч нарыг 6 сараар бэлтгэж сургалтын онол, дадлагын хичээл хоорондын уялдаа холбоог сайжруулсан нь суралцагчдын хувьд сэтгэл ханмжтай гэж үнэлсэн нь манай орны сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн мэргэшсэн сувилагчдын сургалтын цаг, кредит, хугацааг шинэчлэх хэрэгцээтэй байгаатай ижил байлаа.

Дүгнэлт:

1. Сэтгэцийн эрүүл мэндийн мэргэшсэн сувилагчийг чадавхжуулах 6 сарын сургалтанд хамрагдагсад энэхүү туршилт сургалтанд дийлэнх нь сэтгэл ханамжтай, цаашид энэ сургалтын үргэлжүүлэх хүсэлтэй байна.
2. Сэтгэцийн эрүүл мэндийн мэргэшсэн сувилагчийг чадавхжуулах сургалтанд оролцогчдын сургалтын өмнөх болон дараах өөртөө итгэлтэй байдлын үнэлгээг харьцуулахад 6 сарын сургалтын явцад сувилагчид сэтгэцийн эмгэгтэй хүмүүстэй ажиллахдаа өөртөө итгэлтэй байдал нь нэмэгдсэн байна.

Ном зүй:

1. *Postgraduate Medical Education WFME Global Standards 2015 ©WFME 12, P .11*
2. *АШУҮИС, МСА-ны тайлан. 2019.X.24.*
3. *ЭМЯ. "Сэтгэцийн эрүүл мэнд" үндэсний хоёр дахь (2010-2019) хөтөлбөр дэх "Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж"-д хийсэн хөндлөнгийн үнэлгээний тайлан. Х. 34.*
4. *Val Goodwina Rose Mc Masterb Sandra Hydec "Qualitative evaluation of a postgraduate course in mental health nursing" Nurse Education in Practice Volume 36, March 2019, P. 40-46*
5. *Jean Shinners, Jennifer Graebe "Continuing Education as a Core Component of Nursing Professional Development" [J Contin Educ Nurs. 2020;51(1):6-8].*
6. *Allen, P. (2019). Professional resilience through continuing education—A possible benefit.The Journal of Continuing Education in Nursing, (50) P. 51–*52.

On the need for pilot training to empower nurses specializing in mental health

Odgerel L[1], Solongo D[1], Oyungoo B[1], Fiona Nolan[2], Khishigsuren Z[3]

[1]MNUMS School of Nursing
[2]Anglia Ruskin University, United Kingdom[5]
[3]MNUMS, School of Medicine
E-mail: odgerel.l@mnums.edu.mn, Tel: 94947755

Background: In many parts of the world, 6-14 months are required to train a CEM nurse. In Mongolia, the School of Nursing of the Academy of Sciences of Mongolia and the National University of Science and Technology are preparing postgraduate training in this field for 3-4 months.

Materials and Methods: To examine the need for pilot training to build the capacity of mental health nurses. A 6-month capacity building training for mental health nurses was conducted using a descriptive survey model. A total of 17 nurses were included in the study, including a nurse from the National Center for Narcology and the local psychiatric clinic. Fiona Nolan's (2018) confidence level of mental health registered nurses scales (Anglia Ruskin University) used a standard sheet of 24 questionnaires to assess the self-confidence of specialized nurses. The research was developed using SPSS-24 software.

Results: A total of 17 nurses were surveyed, with an average age of 36.3±9.4 for men n=2 (12%) and women n=15 (88%). The students were 100% nurses. 30% of the respondents are from rural areas and 70% are from Ulaanbaatar.

Conclusion: There is a need to continue the 6-month capacity building training for mental health nurses.

Keywords: specialization, program, training, evaluation, nurse.